

# ГЭР БҮЛ САЛАХ НЬ ХОХИРОЛТОЙГ МЭДЭХ



Багш Д.Уранцэцэг II улирал. Хичээл №3  
Email:[D.Urantsetseg@must.edu.mn](mailto:D.Urantsetseg@must.edu.mn)

# ТУЛГУУР ОЙЛГОЛТ

- Буруу юм хийхийг “Гэм” гэнэ.
- Ямар нэг алдаа дутагдлыг “Гэм алдал” гэнэ
- Алдаа мадгийг “Гэм унал” гэнэ.
- Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэг төр, алдар хүнд, эд хөрөнгөд халдах, нийгэмд аюултай гэм буруутай үйлдлийг “Гэм хор” гэнэ.
- “Гэр бүлийн хүчирхийлэл” гэж хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхүй юм
- “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч” гэж гэр бүлийн хүчирхийллийн улмаас сэтгэл санаа, эдийн засаг, бие махбод, бэлгийн халдашгүй байдлаараа хохирсон хүнийг хэлнэ.
- “Түр хамгаалах байр” гэж хохирогчийг тодорхой хугацаагаар байрлуулан үйлчилгээ үзүүлэх зориулалт бүхий стандарт хангасан газрыг хэлнэ.
- “Хамтран амьдрагч” гэж гэрлэлтээ бүртгүүлээгүй ч харилцан тохиролцсоны үндсэн дээр гэр бүлийн харилцаа үүсгэн хамтран амьдарч байгаа этгээдийг хэлнэ.
- “Хүчирхийллийн болзошгүй эрсдэл” гэж гэр бүлийн хүчирхийлэлд хүргэж болзошгүй, эсхүл хүчирхийлэл дахин үйлдэгдэх нөхцөл байдлыг хэлнэ.

# ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦААГ ХҮНДРҮҮЛДЭГ ЗҮЙЛ

- тушаах
- шууд зааварчлах
- болгоомжлох
- зэмлэх
- сөрөг үнэлгээг шууд өгөх
- тохуурхах
- нэр хаяг зүүх
- мөрдөх
- байцаах
- анхаарал халамж сулрах
- асуудлаас зугтах гэх мэт зүйлүүд

# ГЭРЛЭЛТ, ЦУЦЛАЛТЫН НЭГДСЭН ТОО

Аймаг	Гэр бүлийн байдал	2016 он	2017 он	2018 он	2019 он
Улсын дүн	Гэрлэлт	16,778	20,470	21,020	20,043
	Цуцлалт	4,003	3,945	4,201	4,262
Улаанбаатар	Гэрлэлт	8,288	10,399	10,890	10,721
	Цуцлалт	2,630	2,448	2,528	2,713
Төвийн бүс	Гэрлэлт	2,202	2,603	2,913	2,503
	Цуцлалт	584	605	683	686
Хангайн бүс	Гэрлэлт	2,696	3,406	3,344	3,141
	Цуцлалт	458	519	601	505

## **11 дүгээр зүйл. Гэрлэлт дуусгавар болох**

11.1.Гэрлэгч нас барсан болон түүнийг нас барсан гэж зарласан шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн гэрлэлт дуусгавар болсонд тооцогдоно.

11.2.Гэрлэлтийг захиргааны буюу шүүхийн журмаар цуцалсан, эсхүл хүчин төгөлдөр бус гэж тооцсон бол гэрлэлт дуусгавар болно.

## **12 дугаар зүйл. Гэрлэлт цуцлах журам**

12.1.Гэрлэлтийг хуульд заасан үндэслэлээр захиргааны буюу шүүхийн журмаар цуцална.

12.2.Эхнэр нь жирэмсэн буюу хүүхэд нь нэг нас хүрээгүй, эсхүл хариуцагч хүндээр өвчилсөн тохиолдолд гэрлэлтийг цуцлахыг хориглоно.

12.3.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний гэрлэлт цуцлах асуудлыг шийдвэрлэхэд энэ хуулийг баримтлана.

# ГЭРЛЭЛТИЙГ ЗАХИРГААНЫ ЖУРМААР ЦУЦЛАХ

Гэрлэлтээ цуцлуулахыг харилцан зөвшөөрсөн, 18 хүртэлх насны хүүхэдгүй, эд хөрөнгийн маргаангүй гэрлэгчид энэ тухай тус тусдаа бичиж, гарын үсэг зурсан хүсэлтээ улсын бүртгэлийн байгууллага, хилийн чанадад ажиллаж байгаа монгол улсын дипломат төлөөлөгчийн газарт гаргана.

- **14 дүгээр зүйл. Гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлах**
- 14.2.Шүүх гэрлэгчдийг эвлэрүүлэхэд 3 сарын арга хэмжээг эвлэрүүлэн зуучлагчаар дамжуулан хэрэгжүүлнэ.
- 14.4.Гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл, дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон бол шүүх энэ хуулийн 14.2-т заасан эвлэрүүлэх арга хэмжээ авахгүйгээр гэрлэлтийг цуцална.
- 14.7.Хүүхэд долоо ба түүнээс дээш настай бол асрамжийн асуудлыг шийдвэрлэхэд түүний саналыг харгалзан үзнэ.
- 14.11.Гадаад улсад байнга оршин суугаа Монгол Улсын иргэн гэрлэлтээ Монгол Улсад захиргааны ба шүүхийн журмаар цуцлуулж болно.



# ГЭР БҮЛИЙГ СЭТГЭЛИЙН ЗОВЛОНД УНАГАДАГ ШАЛТГААН

Гэр бүлийг сэтгэлийн зовлонд унагадаг шалтгаан	Үр дагавар
Архинд донтох эмгэг	Гэр бүлийн эдийн засаг доройтох, хэрүүл маргаан хийх, хүчирхийлэл үйлдэх, айдастай болох.
Үл ойлголцол	Хэрүүл маргаан, гэр бүл салах.
Хүчирхийлэл	Гэр бүл салах, хүүхэд айдаст автах.
Мансуурах	Сэтгэл гутрал, эдийн засаг доройтох, амиа хорлох, хамт олон найз нөхөдгүй болох, бусдыг залилах, хулгайлах.
Мөрийтэй тоглоом	Хулгай хийх, гэр бүлдээ анхаарал тавихгүй болох, дархлаа сулрах, гадуур тэнэх.
Дэлгэцийн донтолт	Амархан уурлаж бухимдах, гуниглах, сэтгэл түгших, ганцаараа байхыг илүүд үзэх, худлаа ярих, сэтгэл гутрах, нойргүйдэх, өөрийгөө хянах чадваргүй болох.
Өвчлөл	Сэтгэл санаа тавгүйтэх, гуниглах.



# ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХЭЛБЭР (2016 он)

Бие  
махбодийн  
хүчирхийлэл

Эдийн засгийн  
хүчирхийлэл

Сэтгэл  
санааны  
хүчирхийлэл

Бэлгийн  
хүчирхийлэл

### Зөв хариултаа тайлбарлан бичээрэй

1. Найз чинь маш ууртай байвал чи яах вэ?
  - А. Хараагүй мэт дүр үзүүлнэ
  - Б. Юу болсныг асууна
  - В. Сонирхолтой яриа өрнүүлнэ
2. Найз чинь зочдынхоо өмнө бүдүүлэг авир гаргавал яах вэ?
  - А. Чихэнд нь соёлтой харилцааг зааж өгнө
  - Б. Зочдын анхаарлыг өөр зүйлд хандуулна.
  - В. Адилхан авир гаргана.
3. Төрсөн сарыг чинь мартаад өдрийг чинь мартаагүй чамд баяр хүргэвэл чи яах вэ?
  - А. Баярын мэндчилгээг талархан хүлээж авна.
  - Б. Дараа сарын энэ өдөр баяр хүргээрэй гэж хэлнэ.
  - В. Сарыг нь андуурсан ч сайхан сэтгэл гаргасанд нь талархлаа илэрхийлнэ.